

САНАЛЫН ХАЙРЦАГНЫ ТУХАЙ

Иргэдээс Монгол улсын Их хурал, түүний өргөдлийн байнгын хороонд хандан гаргасан өргөдлийг хүлээн авах саналын хайрцагны нууцлалыг ханган битүүмжлэн лацдаж аймгийн **ИРГЭНИЙ ТАНХИМД** 2015 оны 02 дугаар сарын 12-ны өдөр байрлууллаа.

Хууль тогтоох үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, иргэдээс хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих асуудлаар Улсын Их Хуралд өргөдөл гаргах боломжийг бүрдүүлэх зорилгын хүрээнд иргэдээс Монгол Улсын Их Хурал, түүний Өргөдлийн байнгын хороонд хандан гаргасан өргөдлийг саналыг хайрцгаар дамжуулан хүлээн авах, түүний нууцлалыг хангах, Байнгын хороонд шуурхай хүргүүлэхтэй холбогдсон харилцааг аймгийн Засаг даргын Тамгын газар хариуцан зохион байгуулж байна.

Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарах дараах асуудлаар гаргасан өргөдлийг энэ саналын хайрцгаар дамжуулан хүлээн авна.

- 1.Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг боловсронгуй болгох асуудалд санал өгөх.
- 2.Хууль, Улсын Их хурлын бусад шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих.
- 3.Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудын шийдвэр эрх зүйн актуудыг хянуулах.
- 4.Байгууллага, хувь хүний эрх нь зөрчигдсөнтэй холбоотой асуудал
- 5.Иргэний амьдарч буй орон нутагтай холбоотой санал, гомдол

Өргөдөлд өргөдөл гаргагч овог нэр, өөрийн оршин суугаа газрын нэр болон шуудангийн хаяг, утасны дугаар, өргөдлийнхөө агуулгыг ойлгомжтой, тодорхой товч илэрхийлж **250** үгэнд багтаан бичиж өөрийн гарын үсгээ заавал зурсан байна.



Саналын хайрцгийг Иргэний танхимд байрлуулж цугларсан өргөдлийг **14** хоног тутамд хариуцсан мэргэжилтэн Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороонд шуудангийн хаягаар хүргүүлнэ.

АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР